

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР
НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Баярсайхан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, стандартыг хариуцах байгууллагыг тодорхой болгох, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах зардлын хувь хэмжээг 5.0 хүртэл хувиар нэмэгдүүлэх, ажлын талбай болон гадна орчинд хүн гэмтэж бэртсэн, амь наасаа алдсан тохиолдолд ажил олгогч хохирлыг нөхөн төлөх, эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг заавал даатгуулах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг зохицуулалтыг тусгажээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэгдэж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа Эрүүл мэнд, спортын яамнаас эрүүл ахуйн чиглэлээр өгсөн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 20 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар хууль санаачлагчаас асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр, Д.Хаянхярваа, С.Эрдэнэ нар хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, шийтгэлийн хэмжээг ялгаатай тогтоох, хариуцлагын хэмжээг хөдөлмөрийн хөлсны доод хэмжээтэй холбож хэрэглэх нь хэр оновчтой байгааг анхаарах, барилга болон үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ахуйн наад захын шаардлагыг хангах зэрэг саналуудыг тус тус гаргалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Д.БАТЦОГТ

